



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А139

Хэрлэн сум

Чингис хотын бохир усны гол коллектор,  
дулааны шугам, дулааны станцын ажлын хэрэгжилтийг  
зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Чингис хотын бохир усны гол коллектор, дулааны шугам, дулааны станцын ажлын гүйцэтгэлийг хурдасгаж, оролцогч талуудын уялдаа холбоог ханган ажлын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч:

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын  
дарга

Нарийн бичгийн  
дарга:

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын  
Барилга, хот байгуулалтын хэлтсийн инженерийн дэд  
бүтэц хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн  
Аймгийн Ерөнхий архитектор

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын  
Барилга, хот байгуулалтын хэлтсийн хяналтын инженер

Хэрлэн сумын Засаг даргын орлогч

“Хэнтий Ус” ХХК-ийн ерөнхий инженер

2. Ажлын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, ахиц гарсан үр дүнг тухай бүр танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д. АЮУРБУНЬ



